



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО



МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

*Эрчим хүч хэмнэлтийн хэлтсийн дарга
Ц.АТАРЖАРГАЛ*

Улаанбаатар хот
2016 он

Хууль боловсруулах шаардлага

- Гадаад хүчин зүйл:

- Эрчим хүчний анхдагч эх үүсвэрийг ариг гамтай хэрэглэх

/Нүүрс, газрын тос, байгалийн хий ... г.м./

- Байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах

/Дэлхийн дулаарал, хүлэмжийн хийн ялгарал, CO₂/

- Тогтвортой эрчим хүчний хөгжлийг хангах

- Дотоод хүчин зүйл:

- Хөрөнгө оруулалтын бага зардлаар эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах

/1МВт Эрчим хүч хэмнэх = 1МВт эрчим хүчний эх үүсвэр барих/

- Хэрэглээний бүхий л түвшин дэх эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх

/Үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт, хэрэглэгч/

- Шинэ техник, технологийг нэвтрүүлэх, хөгжлийг хурдасгах

Дэлхий нийтийн чиг хандлага

- | | |
|------------------|---------------------------|
| 1. Япон 1974 | -Газрын тосны үнийн шок |
| 2. АНУ 1976 | -Газрын тосны хямрал, DSM |
| 3. Энэтхэг 1998 | -ЭХ-ний Хомсдол |
| 4. Европ-27 2006 | -Бодлогын өөрчлөлт |
| 5. ӨАБНУ 2008 | -Хомсдол |
| 6. ОДХАф 2008 | -Хомсдол+Бодлого |



**UNITED NATIONS DECADE OF
SUSTAINABLE ENERGY FOR ALL
2014-2024**

Sustainable Energy for All is focused on achieving three objectives



ENERGY ACCESS


RENEWABLE ENERGY





ENERGY EFFICIENCY




2014 International Energy Efficiency Scorecard



	НҮҮРС	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ		
		УС	НАР	САЛХИ
Геологийн Нөөц	172,5 Тэрбун.тн	56.2 ³ Тэрбум кВт.цаг	1200-1400 ³ кВт/метр	836.8 ³ тэрбум кВт.цаг
Энэ нөөцөөрөө дэлхийд	10 байр	-	-	-
Нөөц ашиглалт 2015 онд	23,9 сая тонн	62,2 сая кВт.цаг	0,96 сая кВт.цаг	152,6 сая кВт.цаг




**Дэлхийн хамгийн их нүүрсний нөөцтэй улс орнуудын жагсаалт
(тэрбум тонн)**




**3.2. Олборлосон, борлуулсан, экспортолсон нүүрсний хэмжээ,
мян.тн, 2009-2015**




Суурилагдсан хүчин чадал




Эх үүсвэрийн насжилт




ТЭХС-ийн оргил ачааллын судалгаа, МВт




Эрчим хүчний үйлдвэрлэл



Цахилгаан эрчим хүчний хэрэглээ, 2015 он



Эрчим хүчний хэрэглээний өсөлтийн судалгаа, сая кВт.ц



Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль 2015 оны 11 сарын 26-нд УИХ-аар батлагдсан.

Энэхүү хуулийн зорилт нь эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулах бөгөөд 5 бүлэг, 17 зүйлтэй байхаар боловсруулсан болно.

ГАРЧИГ	-“Эрчим хүч хэмнэлтийн тухай”
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	-Нийтлэг үндэслэл
ХОЁРДУГААР БҮЛЭГ	-Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх
ГУРАВДУГААР БҮЛЭГ	-Эрчим хүч хэрэглэгчдийн эрх, үүрэг
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	-Эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээ
ТАВДУГААР БҮЛЭГ	-Бусад зүйл

Хуулийн хамрах хүрээ:



Зохицуулах харилцаа:

- Засгийн газар
- Төрийн захиргааны төв байгууллага
- Эрчим хүчний зохицуулах хороо, /Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл
- Аудит, Аудитын байгууллага, Аудитор
- Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллага /ESCO/
- Үүрэг хүлээсэн хэрэглэгч
- Хэмнэлтийн менежер

Засгийн газрын бүрэн эрх

- 5.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах;
- 5.1.2.эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр батлах;
- 5.1.3.энэ хуулийн 9.1.9-т заасан журам батлах.
 - Үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй холбоотой,
 - Эрчим хүчний Аудит хийхтэй холбоотой,
 - Аудитор, менежер бэлтгэх, мэргэшүүлэх сургалт, гэрчилгээ олгохтой холбоотой,
 - Аудитын байгууллага, Мэргэжлийн байгууллагыг магадлан итгэмлэхтэй холбоотой,

Төрийн захиргааны төв байгууллага:

6.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

6.1.2.эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулах чиглэлээр бараа бүтээгдэхүүн, материал, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон эрчим хүч хэрэглэх машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж, ажил, үйлчилгээнд мөрдөх норм батлах, стандарт батлуулах;

6.1.3.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.

Хуулийг хэн хэрэгжүүлэх вэ?

ЭХЗХ буюу ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ЗӨВЛӨЛ

8.1.Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг Эрчим хүчний зохицуулах хороо хэрэгжүүлнэ.

8.2.Эрчим хүчний зохицуулах хорооны бүтцэд эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй тусгайлсан нэгж байна.

Хэмнэлтийн зөвлөлийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох эрх зүйн боломж нээлттэй байна.

Хэмнэх, үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой харилцааг журмаар зохицуулах

Хуулийг яаж хэрэгжүүлэх вэ?

ЭРЧИМ ХҮЧНИЙ

Аудит, Аудитын байгууллага, Аудитор

Хуулийн төслийн зорилтот бүлэгт хандсан;

- Эрчим хүчний хэрэглээнд нь дүн шинжилгээ хийх
- Дүгнэлт гаргах
- Үр ашгийг тооцох
- Эрчим хүч хэмнэх зөвлөмж өгөх
- Тайлан гаргах

Хараат бус үйл ажиллагаа

Хуулийг яаж хэрэгжүүлэх вэ?

Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага /ESCO/

Үүрэг хүлээсэн хэрэглэгч болон хүсэлт гаргасан хэн бүхэнд Эрчим хүчний аудитын зөвлөмжийн дагуу хэмнэлт, үр ашгийн бүхий л үйлчилгээг үзүүлэх байгууллага.

Эрчим хүчний Аудитын дүгнэлтийг үндэслэн өөрийн хөрөнгө оруулалтаар тухайн байгууллагын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийг бий болгоно.

Хуулийн төслийн талаар

Зорилтот бүлэг:

-ҮҮРЭГ ХҮЛЭЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧ

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн гол үзэл баримтлал нь **Албадлагын** шинжийг агуулсан, **ҮҮРЭГ ХҮЛЭЭЛГЭХ** замаар эрчим хүчийг хэмнүүлэх юм.

Эрчим хүчний жилийн хэрэглээ нь Засгийн газрын тогтоосон хэмжээнээс илүү гарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.

Хуулийг яаж хэрэгжүүлэх вэ?

Хэмнэлтийн менежер

Хуулийн зорилтот бүлэгт эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр ажиллах орон тооны ажилтан байна.

Энэ бол шинэ орон тоо үүсгэх асуудал биш бөгөөд тухай ажил үүргийн чиглэлийн дагуу хавсран гүйцэтгэх бүрэн боломжтой юм.



Эрчим хүч хэмнэлтийн менежер болох үе шат

1

- Үүрэг хүлээсэн хэрэглэгчдээс томилогдсон (3 сарын дотор, журамд заасан шаардлага хангасан байх)

2

- Мэргэшүүлэх сургалтад хамрагдах (21 хонгийн сургалтад хамрагдаж, шалгалт өгнө)

3

- Эрчим хүчний зохицуулах хорооноос Эрчим хүч хэмнэлтийн менежерийн гэрчилгээ олгоно (хугацаагүй гэрчилгээ)

Үндсэн үйл ажиллагаа

Төлөвлөх-Байгууллагын
эрчим хүч хэмнэлтийн
төлөвлөгөө боловсруулах

Хянах-Эрчим хүч хэмнэлтийн
мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх
байгууллагын ажил, хэрэгжүүлж
буй хэмнэлтийн хөтөлбөрийн
байгууллага дотоодод
хэрэгжүүлж буй ажилд хяналт
тавих

Хэрэгжүүлэх-Эрчим хүч
хэмнэлтийн хөтөлбөр
боловсруулж,
хэрэгжүүлэх

Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлтэй хамтран ажиллах	Өөрийн байгууллага	Эрчим хүч хэмнэлтийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах
• Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс тодорхойлсон үйл ажиллагааны чиглэлийг мөрдөх. • Зохион байгуулж буй сургалтад хамрагдах. • Жил бүр ажлаа тайлагнах, шаардлагатай тохиолдолд мэдээллээр хангах.	• Байгууллагын эрчим хүч хэмнэлтийн бодлого, жилийн төлөвлөгөөний дагуу эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. • Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах. • Хяналт тавих.	• Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүч хэмнэлтийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулалтыг хийх. • Үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл, хэмжилт хийх нөхцөл боломжоор хангаж хамтран ажиллах. • Хяналт тавих.

Хуулинд оролцогчдын үйл ажиллагаа

Үүрэг хүлээсэн
хэрэглэгч, бусад

Аудитын байгууллага,
Аудитор

Эрчим хүч
хэмнэлтийн зөвлөл

Сургалт

Мэдэгдэл хүлээн авах

Аудитын байгууллагыг
сонгох

Аудитын төлөвлөгөөг
хамтран боловсруулах

Аудитын үйл
ажиллагааг хийлгэх

Хэмнэлтийн арга
хэмжээг хэрэгжүүлэх

Аудитын тайлан,
хөтөлбөр,
төлөвлөгөөний
биелэлт

Судалгаанд хамрагдах

Хэмнэлтийн арга
хэмжээний явцыг
мэдээлэх

Аудит хийх гэрээ
байгуулах

Аудитын үйл
ажиллагааг төлөвлөх

Аудитын үйл
ажиллагааг гүйцэтгэх

Аудитын үр дүнг
тайлагнах

Техникийн болон
менежментийн заавар
зөвлөгөө өгөх

ҮХХ-ийг тодорхойлж,
бүртгэх, мэдэгдэх

Эрх олгох, гэрээ
байгуулах

Төлөвлөгөөтэй
танилцаж, бүртгэх

Аудитын үйл
ажиллагаатай
танилцах

Шалгалт авах ажлыг
зохион байгуулах

Аудитор, менежерт
эрх, гэрчилгээ олгох

Тайланг хүлээн авч,
бүртгэх

Хэрэглэгчийн сэтгэл
ханамжийн судалгаа
авах

Аудитор, менежер
бэлтгэх сургалтын эрх

Суралцагчдыг бүртгэх

Сургалт явуулах

Шалгалт явуулах
хүсэлт гаргах

Тайлагнах

Хөшүүрэг

12.1.Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх урамшууллыг энэ хуулийн 9.1.9.е, Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.8, 6.1.11-д заасан журмаар зохицуулна.

Хариуцлага: Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх талаар ямар нэг алхам хийгээгүй үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд тодорхой хэмжээний хариуцлага тооцно.

- Эрчим хүчний хэмнэлтийн үр дүнд **570,6 сая кВт.ц** буюу **70-75МВт** чадлын эх үүсвэрийг бий болгоно.
- 570,6 сая кВт.ц гэдэг нь бодит нүүрсээр **377,6 мянган тн нүүрс** буюу **5,8 тэрбум төгрөг**ийн түлшний зардал хэмнэгдэнэ.
- **513,5 мянган тн CO₂** хүлэмжийн хийн бууралт болно.
- Хэрэглэгч талдаа үйл ажиллагааны зардлаасаа **73 орчим тэрбум төгрөг** хэмнэнэ.

Саад, бэрхшээл

- Аудитор, менежер зэрэг мэргэшсэн боловсон хүчний хүртээмж, чанар
- Хэрэглэгчийн хандлага, дадал зуршил
- Хэмжүүрийн нөхцөл байдал
- Үнэ тарифын өнөөгийн түвшин
- Урамшуулал, хөшүүрэг эдлэх боломж

Эрчим хүч хэмнэлтийн хуулийн ач холбогдол

- ❖ эрчим хүчний хэмнэлт нь - эрчим хүчний эх үүсвэр болно,
- ❖ эрчим хүч хэмнэлтийн талаар улс орны хэмжээний төрийн нэгдсэн бодлоготой болно,
- ❖ үйлдвэрлэл - дамжуулалт, түгээлт – хэрэглээний түвшинд эрчим хүчний үр ашиг дээшилнэ,
- ❖ улс орны хөгжлийг хурдасгана, (шинэ техник-технологи нэвтрэх боломж бүрдэнэ),
- ❖ мэргэжлийн боловсон хүчний чадавхи сайжирна,
- ❖ эрчим хүчний үнийн өсөлтөд нийгмийн зүгээс гарч буй сөрөг хандлага буурна,
- ❖ хэрэглэгч хэрэглээгээ ухаалгаар удирдах, зохицуулах боломж бүрдэнэ,
- ❖ нийтийн боловсролд зохих хувь нэмрээ оруулна,
- ❖ хүлэмжийн хийг бууруулна – хүн амын эрүүл мэндэд шууд бус байдлаар эерэг нөлөө үзүүлнэ...

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 5 ДУГААР САРЫН 31-НИЙ ХУРАЛДААНААР

- “ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН БОСГО ХЭМЖЭЭ
ТОГТООХ ТУХАЙ” 294 ДҮГЭЭР ТОГТООЛ
- “ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” 295 ДУГААР ТОГТООЛ

Тус тус батлагдаад байна.



ЦАХИЛГААН

Нийт

/1сая кВт.ц ба түүнээс дээш/

220 ААНБ

ДУЛААН

Нийт

/1500Гкал/жил ба түүнээс дээш/

282 ААНБ

ҮҮНЭЭС

Уул уурхай 5 сая кВт.ц: 19 ААНБ
Аж үйлдвэр 3 сая кВт.ц: 17 ААНБ
Улсын төсөвт 2 сая кВт.ц: 14 ААНБ
Үйлчилгээ 2 сая кВт.ц: 21 ААНБ
НИЙТ: 71 ААНБ

5000Гкал/жил түүнээс дээш:
-Улсын төсөвт: 15 ААНБ
-Үйлдвэр, ААН: 22 ААНБ
НИЙТ: 37 ААНБ

ТЗЭ: 40 ААНБ
НИЙТ: 120 ААНБ

Журмын нэр:

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө, боловсруулах аргачлал, тайлагнах журам

Зорилго:

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах

Бүлэг – 7:

Зохицуулах харилцаа:

**Нийтлэг
үндсэлэл:**

Журмын зорилго, журмын хамрах хүрээ, хэрэгжүүлэгч

**Нэр томъёоны
тодорхойлолт:**

Холбогдох хуулинд дурдсанаас бусад нэр томъёог тайлбарласан.

- *Эрчим хүч хэмнэх хөтөлбөр*
- *Эрчим хүчний аудитын тайлан*

Засгийн газар: Босго хэмжээг **3 жил тутамд** тогтооно.

ЭХХЗөвлөл: ҮХХ-ийг **ТОДОРХОЙЛОХ, БҮРТГЭХ, МЭДЭГДЭХ**

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн **ангилал:**

- **Эрчим хүчний салбар буюу ТЗЭ**
- **Уул уурхай /олборлолт, боловсруулалт/**
- **Аж үйлдвэр /хүнд, хөнгөн, жижиг дунд/**
- **Төсөвт байгууллага /улсын болон орон нутгийн/**
- **Үйлчилгээ, бусад**

Үүрэг хүлээсэн хэрэглэгчээс хасах:

- ✓ **Хэрэглээ нь босго хэмжээнээс доош орсон /ХЭМНЭСНЭЭР/**
- ✓ **Аудитын дүгнэлт, Зөвлөлийн шийдвэрээр**

**ҮХХ-ийг
тодорхойлох,
бүртгэх:**



ҮХХ-ийн
хэрэгжүүлэх үйл
ажиллагаа:

1. Хэмжүүржүүлэх ажлыг хэрэгжүүлэх
2. 3 сарын дотор МЕНЕЖЕР томилох
3. Менежерийг сургалтад хамруулах, эрхийг нь баталгаажуулах
4. 6 сарын дотор сүүлийн 2 жилийн эрчим хүчний хэрэглээний мэдээллийг Зөвлөлд хүргүүлэх
5. 18 сарын дотор Эрчим хүчний аудит хийлгэх
6. Цаашид 3 жил тутам Аудит хийлгэх
7. Эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
8. Менежерийг томилох, чөлөөлөх бүр Зөвлөлд мэдэгдэх
9. Менежерийг ажиллах нөхцлөөр хангах
10. Менежерийн тоог нэмэгдүүлж болох
11. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх явцад шаардлагатай заавар чиглэл авах

Аудит хийлгэх хугацааг 12 хүртэл сараар 1 удаа хойшлуулах нөхцөл:

1. Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс зогссон, дампуурсан,...
2. Үйл ажиллагааны өөрчлөлт, засвар, өргөтгөл хийж байвал
3. Барилга байгууламжийн байршил өөрчлөгдвөл
4. Үйл ажиллагааг хэсэгчлэн зогсоосон, эсхүл хуваагдсан

Мэдээлэх,
тайлагнах:

1. Хэмнэлтийн төлөвлөгөөг өмнөх оны 12 сарын 1-ний дотор ирүүлэх
2. Тайланг дараа оны 3 сарын 1-ний дотор ирүүлэх
3. төлөвлөгөө, тайланг менежер болон байгууллагын удирдлага хамт баталгаажуулах
4. Аудит хийлгэсэн тайланг тухай бүр Зөвлөлд ирүүлэх

Журмын нэр:

Эрчим хүчний аудит хийх журам

Зорилго:

Аудитын үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтын дэс дарааг тодорхойлох, аудитын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тогтоох, аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах

Бүлэг – 7:

Зохицуулах харилцаа:

**Нийтлэг
үндсэлэл:**

Журмын зорилго, журмын хамрах хүрээ, хэрэгжүүлэгч, зарчим

**Нэр томъёоны
тодорхойлолт:**

Холбогдох хуулинд дурдсанаас бусад нэр томъёог тайлбарласан.

- *Эрчим хүчний аудитын тайлан*
- *Үйлчлүүлэгч*
- *Иж бүрэн аудит*
- *Хэсэгчилсэн аудит*
- *Аудитын нотолгоо*
- *Хамтарсан аудит*

**Аудитын төрөл,
үе шат:**

Төрөл:

Иж бүрэн аудит:

Хэсэгчилсэн аудит:

Аудит хийх үйл ажиллагааны үе шат:

Нэгдүгээр түвшин буюу хэмнэх боломжийн талаар **ерөнхий дүгнэл боловсруулах, тайлагнах**

Хоёрдугаар түвшин буюу **Цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх**

Аудит хийх гэрээ:

1. Аудитын төрөл, үе шатаас хамааруулан аудитын байгууллага, аудитор гэрээний үндсэн дээр хамтарсан аудит хийж болно.
2. Гэрээний загварыг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл гаргана.
3. Гэрээний загварт гэрээний эрх зүйн нийтлэг асуудлыг тусгана.

Аудитын үйл ажиллагааны үе шат:

1. **Төлөвлөх**
2. **Гүйцэтгэх**
3. **Үр дүнг тайлагнах**
4. **Зөвлөмж өгөх**

Аудитын үйл ажиллагааг гүйцэтгэх дараалал:

1. Мэдээлэл цуглуулах, баталгаажуулах
2. Цуглуулсан мэдээллийг хянаж, үнэлэх;
3. Холбогдох норм, стандартад нийцэж буй эсэхийг тодорхойлох;
4. Тооцоо, судалгаа, дүн шинжилгээ хийх;
5. Тайлан боловсруулах;
6. Аудитын дүгнэлт, зөвлөмж гаргаж, тайлагнах.

Зөвлөмжид:

- Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг тодорхойлсон техник, эдийн засгийн үндэслэлтэй, санхүүгийн боломжит хувилбаруудыг санал болгох.
- Зөвлөмжийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаар танилцуулах

Аудит хийх:

Аудитын байгууллага, аудиторын эрх, үүрэг:

- Байгууллагатай танилцах, шаардлагатай мэдээллийг гаргуулан авах
- Уулзалт ярилцлага хийх
- Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөх
- Цуглуулсан мэдээллийг зөвхөн аудитын үйл ажиллагаанд ашиглах
- Зөвлөлд аудитын үйл ажиллагааны явцыг танилцуулах
- Дүгнэлт, зөвлөмжийг нотолгоонд тулгуурлан гаргах, тайлбарлах
- Хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой техникийн болон менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх

Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

- Аудитын байгууллагыг сонгох, аудит хийх нөхцөлөөр хангах, саад учруулахгүй байх
- Аудитын үйл ажиллагаатай холбоотой санал асуулгыг Зөвлөлд хүргүүлэх
- Аудитын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол гаргах

Журмын нэр: Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журам

Зорилго: Энэхүү журмаар Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6, 9.1.8 дугаар зүйлд тус тус заасны дагуу эрчим хүчний аудитор /цаашид “аудитор” гэх/, эрчим хүч хэмнэлтийн менежер /цаашид “менежер” гэх/ бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, эрх, гэрчилгээ олгох, хүчингүй болгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулна.

Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл аудитор, менежер бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг энэ журамд заасан шаардлагыг хангасан сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

Бүлэг – 8: Зохицуулах харилцаа:

Нийтлэг үндсэлэл: Журмын зорилго, журмын хамрах хүрээ, хэрэгжүүлэгчийг тодорхойлсон.

Холбогдох хуулинд дурдсанаас бусад нэр томъёог тайлбарласан.

Нэр томъёоны тодорхойлолт:

- Сургалтын байгууллага
- Сургалтын хөтөлбөр
- Сургагч багш
- Шалгалтын комисс...

Сургалтын байгууллагад тавих шаардлага:

Сургалтын байгууллагад тавих шаардлага:

- Сургалтын үйл ажиллагаа эрхлэх орчин нөхцөл, анги танхим
- Сургагч багш буюу Зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдсан мэргэшсэн, зөвлөх инженер, багш.
- Дадлагажуулах төлөвлөгөө /Дадлагын газар/, Туршилтийн лаборатори, Аудитор, менежерийн үйл ажиллагаанд ашиглах багаж, хэмжүүрийн хэрэгсэлтэй байх

Зөвлөл:

- Сургалт явуулах асуудлыг 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- Гэрээг 1 жилээр байгуулна, 2 жилээр сунгана.
- Олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.

Сургалтад хамрагдагчид тавих шаардлага:

Аудитор, менежерийн эрх хүссэн өргөдөл гаргагч нь:

- Инженер, Инженер-эдийн засаг, **Бакалавр** түүнээс дээш
- Менежер нь мэргэжлээрээ **3-аас** доошгүй жил ажилласан
- Аудитор нь мэргэжлээрээ **8-аас** дээш жил ажилласан
- Сургалтын төлбөр, хураамжийг төлөх

Дээрх шаардлагыг хангасан өргөдөл гаргагчийн материалыг Сургалтын байгууллага хүлээн авч сургалт явуулна.

Аудитор, менежер бэлтгэх, мэргэшүүлэх сургалт:

Сургалт 3 төрөлтэй байна:

- Аудитор- үйлдвэрлэл, үйлчилгээ/ цахилгаан, дулаан, хий/;
- Аудитор- барилгын;
- Эрчим хүч хэмнэлтийн Менежер.

Аудитор,
менежерийн эрх
олгох шалгалт:

Шалгалт хоёр үе шаттайгаар явагдана:
нэгдүгээр шат: ТЕСТ
хоёрдугаар шат: ДАДЛАГА ХАМГААЛАЛТ
ТЕСТ-80% түүнээс дээш тэнцэнэ.
Дадлага ажил 70% түүнээс дээш тэнцэнэ.

Аудитор,
менежерийн
гэрчилгээ:

- Аудиторолгох гэрчилгээ нь **2 жил, 5 жилээр сунгах** хугацаатай байна.
- Менежерийн гэрчилгээ хугацаагүй байна.
- Гэрчилгээний хамт үйл ажиллагааны эрхийг баталгаажуулсан **ҮНЭМЛЭХ** олгоно.
- Аудитор нь **ТЭМДЭГ** ашиглах эрхтэй байна.
- Эрх авсан аудитор, менежерийг мэдээллийн санд бүртгэх, олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл хариуцна.

Бусад:

- Гэрээ байгуулсан сургалтын байгууллага Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс баталсан **сургалтын хөтөлбөрийг** ашиглах эрхтэй ба гуравдагч этгээдэд **дамжуулахыг хориглоно.**

Журмын нэр:	Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам
Зорилго:	Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагыг магадлан итгэмжлэхтэй холбоотой харилцааг зохицуулах
Бүлэг – 8:	Зохицуулах харилцаа:
Нийтлэг үндсэлэл:	Журмын зорилго, журмын хамрах хүрээ, хэрэгжүүлэгчийг тодорхойлсон.
Нэр томъёоны тодорхойлолт:	Холбогдох хуулинд дурдсанаас бусад нэр томъёог тайлбарласан. • <i>Магадлан итгэмжлэл</i> • <i>Магадлан итгэмжлэх комисс</i> • <i>Эрчим хүчний үр ашгийн мэргэжлийн үйлчилгээ</i>
Байгууллагад тавих шаардлага:	Аудитын байгууллагын шаардлага: • Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллага байх • 3-аас доошгүй Аудитортой байх, үндсэн ажилтан байх. • Аудитын үйл ажиллагаанд ашиглах норм, стандартын бүрдэл • Шаардлагатай тоног төхөөрөмжтэй байх.

**Байгууллагад
тавих шаардлага:**

Мэргэжлийн байгууллагын шаардлага /ESCO/:

- Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллага байх
- **Эрчим хүчний барилга угсралт**, шугам сүлжээ барьж байгуулах тусгай зөвшөөрөлтэй байх
- **Барилга угсралтын** үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх
- ТЗ-ийн чиглэлээр сүүлийн 2 жилд тогтмол үйл ажиллагаа эрхэлсэн байх
- Санхүүгийн чадавхи, өөрийн хөрөнгө оруулалтаар ажил хийх боломжтой байх.

**Магадлан
итгэмжлэл олгох:**

- Журамд заасан шаардлагыг хангасан байгууллага холбогдох материалуудыг бүрдүүлэн Зөвлөлд **ӨРГӨДӨЛ** гаргана.
- Материал хүлээн авснаас хойш 3 хоногт багтаан материалын чанарт үнэлгээ өгч өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.
- Материал шаардлага хангасан гэж үзвэл ажлын 30 хоногт багтаан Зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ.

**Магадлан
итгэмжлэлийн
хугацаа, түүнийг
сунгах:**

- Магадлан итгэмжлэлийн хугацаа эхний удаа 2 жил, сунгалт 5 хүртэл жил байх
- Магадлан итгэмжлэлийг сунгахад өмнө нь хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээний чанар, үр дүнг гол шалгуур болгоно.

**Магадлан
итгэмжлэлийг
хүчингүй болгох:**

Магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох:

- Зөрчлөө арилгаагүй бол
- Магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан
- Дампуурсан, татан буугдсан г.м.

**Магадлан
итгэмжлэгдсэн
байгууллагыг
бүртгэх,
мэдээллийн сан
үүсгэх:**

- Магадлан итгэмжлэгдсэн байгууллагыг Зөвлөл бүртгэж, олон нийтэд ил тод мэдээлэх.
- Магадлан итгэмжлэгдсэн байгууллагыг мэдээллийн санд байршуулах, хэрэглэгчдийг мэдээлэл авах боломжоор хангах
- Хүчингүй болсон магадлан итгэмжлэлийг бүртгэлээс хасах

Бусад:

- Магадлан итгэмжлэл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой маргааныг Зөвлөлөөр шийдвэрлэнэ.
- Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхээр шийдүүлнэ.



БАЯРЛАЛАА

Web site: www.erc.mn

